5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	154,970.45

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан / мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,045,654.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,045,654.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,984,542.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	23,671.13
210101	Үндсэн цалин	23,671.13
2104	Хангамж, бараа материалын зардал	11,242.40
210401	Бичиг хэрэг	335.00
210402	Тээвэр, шатахуун	8,167.93
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,739.47
2105	Нормативд зардал	36,598.94
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,875.62
210502	Хоол, хүнс	8,723.32
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,777.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,777.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,892,252.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,892,252.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,111.65
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	59,207.47
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	59,207.47
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,904.18
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,904.18
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,045,733.87
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,045,733.87
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,923,969.04
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	102,529.26
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,235.57
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	79.72
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	79.72

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цогт-Овоо сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд шилэн данс, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтыг сайжруулахтай холбогдсон зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хишигбат гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Сүрэнжаргал, аудитын менежер Т.Хонгорзул, дарга, тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1-43 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цогт-Овоо сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Нутаг дэвсгэртээ экологийн тэнцвэрийг зохистой хадгалан, дэд бүтцийг бий болгож, жижиг дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал, газар тариалан, мал аж ахуйн салбаруудыг эрчимтэй хөгжүүлэх, хүн амын тогтвортой, чинээлэг аж төрөх нөхцөлийг ханган, өөрийнхөө бүх үйл ажиллагааг өөрөө санхүүжүүлэхэд аажмаар шилжих нь сумын эрхэм зорилго мөн” гэж тодорхойлжээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлөөр хангах, хамтран хөгжих, төрийн үйлчилгээг гэр бүлд хүргэх, сумын ард иргэдийн тасралтгүй сурч хөгжих боломжоор хангах, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, дэмжих, сургалтын чанарыг дээшлүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаал
- “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал
- “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 онд боловсруулан аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нийт орлого 4,686.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 46.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 32.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг дахин тооцох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 438.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 544.4 сая төгрөг болж 105.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө				
Банканд байгаа бэлэн мөнгө	438.6	544.4	105.8	100.0
Замд яваа мөнгөн хөрөнгө				
Хадгаламж				
Дүн	438.6	544.4	105.8	100.0

Эх сурвалж: Цогт-Овоо сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 532.5 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 5.1 сая төгрөг арилжааны банкны дансанд, 6.8 сая төгрөг нэмэлт санхүүжилтийн дансанд тус тус байршиж байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт байхгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 236.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 264.6 сая төгрөг болж 27.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № Авлагын үлдэгдэл / сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.1	2.3	2.2

Сэврэй сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Татаас, санхүүжилтийн авлага	33.9	89.6	55.7
Зээлийн хүүгийн авлага	3.0	-	3.0
Дансны авлага ТӨҮГ	5.3	10.7	5.4
Татвар, НДШ-ын авлага	0.7	0.5	-0.2
Байгууллагаас авах авлага	0.4	-	0.4
Хувь хүмүүсээс авах авлага	24.8	25.6	0.8
Хувь хүмүүст олгосон зээл	168.5	135.8	-32.7
Дүн	236.7	264.6	27.9

Эх сурвалж: Цогт-Овоо сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага 27.9 сая төгрөгөөр өссөн нь ЭМДЕГ-аас авах даатгалын санхүүжилт илүү нөлөөлсөн байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. дансны эхний үлдэгдэл 0.1 сая, эцсийн үлдэгдэл 0.1 сая төгрөг болж өөрчлөгдөөгүй байна.

Хүснэгт № Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	0.1	0.1	-
Бараа материал бэлтгэх урьдчилгаа			
Цалингийн урьдчилгаа			
Томилолтын урьдчилгаа			
Дүн	0.1	0.1	-

Эх сурвалж: Цогт-Овоо сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт байхгүй байна.

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 550.1 сая, эцсийн үлдэгдэл 663.4 сая төгрөг болж, 113.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	3.5	3.5	-
Эм боох материал	15.3	24.4	9.1
Дуусаагүй үйлдвэрлэл	11.6	11.6	-
Бэлэн бүтээгдэхүүн	63.2	81.0	17.8
Бичиг хэргийн материал	1.0	0.1	-0.9
Аж ахуйн материал	0.2	-	0.2
Сэлбэг хэрэгсэл	0.1	0.2	0.1
Шатах тослох материал	2.0	0.6	-1.4
Хүнсний материал	4.2	2.3	-1.9
Бусад хангамжийн материал	438.1	526.4	88.3
Мал амьтад	10.8	13.3	2.5
Тэжээлийн нөөц	24.7	30.3	5.6
Бусад нөөц	1.8	99.7	97.9
Дүн	550.1	663.4	113.3

Эх сурвалж: Сэврэй сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад хангамжийн материала 88.3 сая төгрөг, бусад нөөц 97.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна-эхний үлдэгдэл 9,252.7 сая, эцсийн үлдэгдэл 11,335.0 сая төгрөг болж 2,082.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	9,108.9		
Тээврийн хэрэгсэл	553.7		
Машин тоног төхөөрөмж	746.0		
Тавилга эд хогшил	262.1		
Зам гүүрийн барилга байгууламж	11.3		
Түүх соёлын дурсгалт зүйл			
Номын фонд			
Бусад үндсэн хөрөнгө	1,366.0		
Ном	34.5		
Программ хангамж	11.1		
Бусад биет бус хөрөнгө	108.4		
Дүн	9,324.6		

Эх сурвалж: Сэврэй сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 28.3 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 457.4 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 3,007.2 сая төгрөг нийт үндсэн 3,492.9 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, 882.2 сая төгрөгийн хөрөнгийн балансаас баланст шилжүүлж, 1,354.6 сая төгрөгийн хөрөнгө акталж нийт 2,236.8 сая төгрөгийн хөрөнгө данснаас хассан байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна-эхний үлдэгдэл 2,752.3 сая, эцсийн үлдэгдэл 4,546.3 сая төгрөг болж, 1,794.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
<u>Богино хугацаат өр төлбөр дүн</u>	4.9	53.8	48.9	2.7
Байгууллагад төлөх өглөг	2.9	38.8	35.9	1.9
Татварын өглөг /ТӨҮГ/		0.12	0.12	0.1
НДШ-ийн өглөг /ТӨҮГ/		0.03	0.03	
Дансны өглөг /ТӨҮГ/	2.0	14.9	12.9	0.7
<u>Урт хугацаат өр төлбөр дүн</u>	2,747.3	4,492.5	1,745.2	97.3
Хойшлогдсон өр төлбөр/ТӨҮГ/	2,747.3	4,492.5	1,745.2	97.3
Нийт дүн	2,752.3	4,546.3	1,794.0	100.0

Эх сурвалж: Сэврэй сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд төсөл сангийн 38.8 сая төгрөг, ОНӨҮГ-ын дансны болон татварын 15.0 сая төгрөгийн өглөг тус тус байна. Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Дэмд од ОНӨААТҮГ-ын 2,073.1 сая төгрөгийн орон нутгийн хөрөнгөөр бэлтгэсэн хагас автомат уурын зуухыг үндсэн хөрөнгөд хүлээн авснаас үүссэн хойшлогдсон өр төлбөр байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,463.6 сая, эцсийн үлдэгдэл 7,602.2 сая төгрөг болж 138.6 сая төгрөгөөр өссөн байна.

Сэврэй сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт № 31. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /САЯ ТӨГРӨГ/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт -/	Дунд эзлэх хувь
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	3,626.5	3,626.5	0	47.8
<u>Өмч /төрийн/ /ТӨҮГ/</u>				
<u>Өмч /хувийн/ /ТӨҮГ/</u>				
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	2,712.0	3,061.8	349.8	40.2
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	1,125.1	913.9	-211.2	12.0
<u>Бодлогын өөрчлөлт алдааны залруулга</u>				
Дүн	7,463.6	7,602.2	138.6	100.0

Formatted: Font: Arial, 10 pt, Font color: Auto

Formatted: Centered, Space After: 0 pt

Эх сурвалж: Сэврэй сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 138.6 сая төгрөгөөр өссөн нь хуримтлагдсан үр дүн өссөнөөс шалтгаалжээ. Мөн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 913.9 сая төгрөг болж 211.2 сая төгрөгөөр буурсан нь дахин үнэлэгдсэн өвс тэжээлийн барилгыг аймгийн Онцгой байдлын газарт шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Сэврэй сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 5/05 дугаар тогтоолд зааснаар Сэврэй сумын Засаг дарга тайлант онд 101.4 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 158.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 156.5 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Төсвийн орлогын		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Урсгал орлого	101.4	158.7	57.3	156.5
Татварын орлого	82.4	138.0	55.6	167.4
Татварын бус орлого	19.0	20.7	1.7	109.1

Эх сурвалж: Сэврэй сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 57.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь Засгийн газраас 101 тогтоолын олгосон ноолуур дэмжлэгийн орлогын 1%-ийн татварын орлого, сумын ИТХ-ын 2021 оны 3/02 тогтоолоор “Малын албан татвар”-ыг тогтоож орон нутгийн төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт

Тус сумын ИТХ-ын 2020 оны 2/08 дугаар тогтоолоор төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,195.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,195.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн ажилласан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь сумын ИТХ-ын 2021 оны 4/03 дугаар тогтоолоор тодотгол хийж 176.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн орлого, зарлагыг 2,372.5 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,372.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,022.7 сая төгрөгийг урсгал зардалд, 349.8 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Нийт зардлын 1,314.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 735.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 322.7 сая төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,218.3 сая, орон нутгийн төсвөөс 744.7 сая, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 170.3 сая төгрөгийг санхүүжилтийг олгосон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 170.3 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 39.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хөрөнгийн зардалд 211.2 сая төгрөг төлөвлөж 145.0 сая төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,923.9 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 102.5 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 19.2 сая нийт 2,045.7 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс: 2,045.6 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.079 сая төгрөгийг болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дэлхий нийтийг хамарсан Ковид 19 цар тахалтай холбоотойгоор өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллаж орон нутгийн нөөц хөрөнгө данс ЗДТГ-ын төсвөөс 34.0 сая төгрөгийн өртөг бүхий ариутгалын бодис, хамгаалах хувцас, хэрэглэл, тээвэр шатахуун, хоол, урамшууллын зардал гаргасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2 ажил, ОНХС-ийн хөрөнгөөр ажил хийгдсэн бөгөөд тухайн ажлуудыг данс бүртгэлд тусгаж ажилласан ч барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, эд хогшлын чанар, хэрэгжилтийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэлт өгөх боломжгүй байлаа.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

Сэврэй сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өмнөх аудитаар өгөгдсөн Шилэн дансны нэгдсэн системд 51 мэдээллийг хугацаа хоцроосон, 15 мэдээллийг огт байршуулаагүй гэсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй алдаа, зөрчил давтагдан гарсан байна. Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд мэдээлбэл зохих 32 мэдээллийг хугацаа хоцроосон, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (1-12 сар) мэдээллээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.3 "энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна", 6.3.6 "хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий мэдээлэл" дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Засаг даргын харьяа байгууллага болох сумын ЗДТГ, ИТХ, Цэцэрлэг, Соёлын төвийн 2021 оны хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудит хийгдэж аудитаар илэрсэн алдаа зөрчлийг асуудлын бүртгэлээр хүргүүлж жилийн эцсийн аудитаар хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Цогт-Овоо сумын Засаг дарга нь өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай санал дүгнэлт авсан бөгөөд өгөгдсөн албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад дараах байдалтай байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжээгүй үлдэгдэл		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	230.2	2	209.2		21.0	90.8
Төлбөрийн акт	1	83.0	1	83.0			100
Зөвлөмж	3	118.4	3	112.7		5.7	95.1
Нийт дүн	6	431.6	6	410.6		21.0	95.3

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг Засаг даргын 2021 оны 12 сарын 06-ны өдрийн 1-408 тоот, 2022 оны 2 сарын 07-ны өдрийн 1-29 тоот албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн гүйцэтгэлийн аудитаар 2021 онд хийгдсэн хөрөнгө оруулалтыг нүдээр үзэж, хэрэгжилтийг шалгах, өмнөх оны аудитаар өгсөн ОНХС-ийн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг давтан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 155.6 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс, 56.2 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 98.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 1.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоолоо.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгах явцад илэрсэн зөрчлийг аудитын дүгнэлтэд хамааруулахгүй бөгөөд залруулагдаагүй 4 зөрчлийн дүн нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 46.9 сая төгрөгт хүрээгүй тул зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үр дүнгийн тайланг мөнгөн гүйлгээний тайлантай тулган баталгаажуулахад дотоод албан томилолт 14,000 төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 27,493,235 төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал 28,737,235 төгрөгөөр зөрүүтэй байна.

Акт

Илрүүлэлт 1: Соёлын төвийг засварлах ажлын гэрээнд зааснаас 13 хоног хугацаа хэтрүүлсэн 1,220,857.80 төгрөгийн алданги суутгаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Соёлын төвийн засварын ажлын гэрээний хугацаа хэтрүүлсэн 13 хоногт ногдох 1,220,857 төгрөгийг гүйцэтгэгч байгууллагаар гаргуулан Төрийн сан банкин дахь (хүү торгуулийн орлого) 100110000988 тоот дансанд төвлөрүүлэх;

Албан шаардлага

Илрүүлэлт 1: Засаг даргын нөөц сангаас 1,244,000 төгрөгийг автомашин сэлбэг худалдан авсан, 180,000 төгрөгийг бичгийн цаас худалдан авч зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 7.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх

Илрүүлэлт 2: Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн тэмдэглэл, шийдвэр, холбогдох тооцоогүй 54,939,445 төгрөгийг зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 4.1, 5.1, 5.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх

Илрүүлэлт 3: Хүчингүй болсон Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан журмыг үндэслэн 1,500,000 төгрөгийг сургалтын төлбөрийн дэмжлэгт, 478,000 төгрөгийг шалган нэвтрүүлэх постонд ажиллаж байгаа албан хаагчдын хоолны материал, хамгаалах хэрэгслийн зардалд, 1,772,850 төгрөгийг оторт яваа малчдад өвс тэжээл хүргэх тээвэр шатахууны зардалд, 216,000 төгрөгийг төгсөх ангийн сурагчдын шагналын зардалд, 647,200 төгрөгийг мэдээллийн самбар хийлгэхэд, 215,000 онцгой комиссын автомашины сэлбэгт тус тус зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх

Илрүүлэлт 4: Төсвийн хэмнэлтийг горимыг зөрчиж чийрэгжүүлэлтийн танхим, тоног төхөөрөмжтэй болох ажилд 36,900,000 төгрөгийг зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Засгийн газрын баталсан Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа тогтоол шийдвэрүүдийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэх

Илрүүлэлт 5: Өмнөх аудитаар өгөгдсөн Шилэн дансны нэгдсэн системд 51 мэдээллийг хугацаа хоцроосон, 15 мэдээллийг огт байршуулаагүй гэсэн албан шаардлагыг

Сэврэй сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

хэрэгжүүлээгүй алдаа, зөрчил давтагдан гарсан байна. Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд мэдээлбэл зохих 32 мэдээллийг хугацаа хоцроосон, 12 мэдээлэл мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." заалтыг үндэслэн хариуцлага тооцох албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэх

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/сая төгрөг/

д/д	Зөрчлийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн тайлангийн аудитаар	3	58.8	1	56.2	1	1.2	1	1.4		
2	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	1	96.7					1	96.7		
3	Нийт дүн	4	155.6	1	56.2	1	1.2	2	98.1		